



ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРЛЫН ТУШААЛ

2026 оны 01 сарын 27 өдөр

Дугаар А/12

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын “Төсвийн тухай” хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, 16.5.4, 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/207 дугаар тушаалын 3.2.5 дахь заалтыг тус тус хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:

1. Монгол Улсын хэмжээнд 2024, 2025 оны эрт болон хожуу нярайн эндэгдэл, нялхсын эндэгдэл /29 хоногтойгоос 1 нас хүртэл/, 1-5 хүртэлх, 5-18 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаанд дүн шинжилгээ хийх, “Хүүхэд яагаад эндэв” судалгааны ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, ажлын хэсгийн удирдамжийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Судалгааны ажлыг хийж гүйцэтгэхэд шаардагдах төсвийн хуваарийг удирдамжийн дагуу боловсруулж, батлуулах ажлыг Хүүхдийн эмнэлзүй эрхэлсэн дэд захирал /Л.Ганбаяр/, Үйл ажиллагаа, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал /Э.Бямбасүрэн/, Тандалт судалгаа, статистикийн албаны дарга /М.Баялаг/ нарт тус тус даалгасугай.


3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал эрсдэлийн албаны дарга /А.Оюунчимэг/-д даалгасугай.

ЗАХИРАЛ 

Ж.ОТГОНБААТАР

1606060174

Захирлын 2026 оны сарын өдрийн
тоот тушаалын хавсралт



2024-2025 оны эрт болон хожуу нярай, нялхас, нэгээс тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаанд дүн шинжилгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн дарга:	Ж.Отгонбаатар, ЭХЭМҮТ-ийн захирал, АУ-ны доктор, Клиникийн профессор
Ажлын хэсгийн орлогч дарга:	Л.Ганбаяр, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлзүй эрхэлсэн дэд захирал, зөвлөх зэргийн эмч, Клиникийн профессор
Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга	Э.Батцэцэг, хүүхдийн тусламж үйлчилгээ хариуцсан чанарын менежер, Хүүхдийн ахлах зэргийн эмч
Гишүүд:	Э.Бямбасүрэн, ЭХЭМҮТ-ийн Үйл ажиллагаа, төлөвлөлт эрхэлсэн дэд захирал М.Баялаг, ЭХЭМҮТ-ийн Тандалт судалгаа, статистикийн албаны дарга, АУ-ын доктор, клиникийн профессор А.Оюунчимэг, ЭХЭМҮТ-ийн Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдлын албаны дарга, АУ-ны магистр, Хүүхдийн зөвлөх зэргийн эмч, Клиникийн профессор

Хүүхэд, нярайн баг:


1. Ш.Чимгээ, ЭХЭМҮТ-ийн Нярайн нэгдсэн тасгийн зөвлөх эмч, АУ-ны магистр, Хүүхдийн зөвлөх зэргийн эмч, Клиникийн профессор
2. Д.Авирмэд, Монгол улсын төрийн соёрхолт, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн ерөнхий мэс заслын зөвлөх эмч, клиникийн профессор
3. Ш.Энхтөр, ЭМЯ-ны Хүүхэд судлалын Мэргэжлийн салбар зөвлөлийн дарга, Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн, АУ-ны доктор, Клиникийн профессор
4. Т.Болормаа, ЭХЭМҮТ-ийн Зүрх судас, холбогч эдийн эрхтэний эмгэг судлалын тасгийн зөвлөх эмч, АУ-ны доктор, Хүүхдийн зөвлөх зэргийн эмч, Клиникийн профессор
5. О.Энхчимэг, ЭХЭМҮТ-ийн Мэдрэлийн эмгэг судлалын тасгийн зөвлөх эмч, АУ-ын магистр, мэдрэлийн тэргүүлэх зэргийн эмч
6. Д.Ганчимэг, ЭХЭМҮТ-ийн Мэдээгүйжүүлэг, хагалгааны нэгдсэн тасаг, Мэс заслын эрчимт эмчилгээний тасгийн зөвлөх эмч,
7. Р.Батсолонго, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч, АУ-ны магистр, Хүүхдийн зөвлөх зэргийн эмч, Клиникийн профессор
8. Д.Чинзоригт, ЭХЭМҮТ-ийн Бөөр, дотоод шүүрлийн эмгэг судлалын тасгийн эрхлэгч, АУ-ны магистр, Хүүхдийн зөвлөх зэргийн эмч, Клиникийн профессор
9. Ч.Наранцэцэг, ЭХЭМҮТ-ийн Нярайн эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч, АУ-ын магистр, хүүхдийн тэргүүлэх зэргийн эмч, Клиникийн профессор
10. Л.Ролзодмаа, ЭХЭМҮТ-ийн Гүйцэд нярай, дутуу нярайн эрчимт эмчилгээний тасгийн эрхлэгч, хүүхдийн тэргүүлэх зэргийн эмч

11. Г.Батцэнгэл, ЭХЭМҮТ-ийн Нярайн эмгэг судлалын тасгийн эрхлэгч, хүүхдийн ахлах зэргийн эмч, АУ-ын магистр
12. О.Туул, ЭХЭМҮТ-ийн Мэдрэлийн эмгэг судлалын тасгийн эрхлэгч, АУ-ны магистр, мэдрэлийн тэргүүлэх зэргийн эмч
13. Б.Ариунхишиг, ЭХЭМҮТ-ийн Амьсгалын эрхтний эмгэг судлалын тасгийн эрхлэгч, хүүхдийн тэргүүлэх зэргийн эмч
14. В.Ганхуяг, ЭХЭМҮТ-ийн Ерөнхий мэс заслын тасгийн эрхлэгч, мэс заслын зөвлөх зэргийн эмч, Клиникийн профессор
15. Д.Чулуунхүү, ЭХЭМҮТ-ийн Мэдрэлийн мэс заслын тасгийн эрхлэгч, мэс заслын тэргүүлэх зэргийн эмч
16. М.Зоригтбаатар, ЭХЭМҮТ-ийн Цээжний мэс заслын тасгийн эрхлэгч, мэс заслын тэргүүлэх зэргийн эмч
17. Б.Хандмаа, ЭХЭМҮТ-ийн Хоол боловсруулах эрхтний эмгэг судлалын тасгийн эрхлэгч, хүүхдийн ахлах зэргийн эмч
18. С.Сэргэлэн, ЭХЭМҮТ-ийн Мэс заслын эрчим эмчилгээний тасгийн эрхлэгч, АУ-ны магистр, Мэс засал мэдээгүйжүүлэг эрчимт эмчилгээний тэргүүлэх зэргийн эмч,
19. Б.Батдулам, ЭХЭМҮТ-ийн Цусны эмгэг, хавдар судлалын тасгийн эрхлэгч, тэргүүлэх зэргийн эмч
20. Ж.Бат-Ундрах, ЭХЭМҮТ-ийн Зүрх судас, холбогч эдийн эмгэг судлалын тасгийн эрхлэгч, АУ-ны магистр, ахлах зэргийн эмч
21. Д.Дүүрэнбилэг, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн Яаралтай тусламжийн тасгийн эрхлэгч
22. М.Ундрэм, ЭХЭМҮТ-ийн Мэдээгүйжүүлэг, хагалгааны нэгдсэн тасгийн эрхлэгч, тэргүүлэх зэргийн эмч, АУ-ны магистр
23. Б.Энхтайван, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эрчимт эмчилгээний тасгийн эмч, АУ-ны магистр, Хүүхдийн зөвлөх зэргийн эмч, Клиникийн профессор
24. А.Солонго, ЭХЭМҮТ-ийн Гүйцэд нярай, дутуу нярайн эрчимт эмчилгээний тасгийн эмч, хүүхдийн ахлах зэргийн эмч
25. Б.Хишигмаа, ЭХЭМҮТ-ийн хүүхдийн тусламж хариуцсан чанарын менежер, Хүүхдийн ахлах зэргийн эмч
26. Э.Маргад-Эрдэнэ, ЭХЭМҮТ-ийн Хүүхдийн эмнэлгийн тусламж үйлчилгээний зохицуулагч

Мэдээлэл орлуулах, боловсруулах баг:

1. М.Баялаг, Тандалт судалгаа, статистикийн албаны дарга, АУ-ны доктор, клиникийн профессор
2. Т.Гантуяа, Тандалт судалгаа, статистикийн албаны судлаач, эмч, тэргүүлэх зэргийн эмч
3. Б.Хишигжаргал, Тандалт судалгаа, статистикийн албаны судлаач, эмч
4. О.Анударь, Тандалт судалгаа, статистикийн албаны судлаач, эмч
5. П.Орхонтуул, Тандалт судалгаа, статистикийн албаны судлаач, ажилтан, БУ-ын магистр
6. Б.Нямбадам, Тандалт судалгаа, статистикийн албаны судлаач, эмч, АУ-ны магистрант
7. Б.Бүрэнжаргал, Тандалт судалгаа, статистикийн албаны нийгмийн эрүүл мэндийн ажилтан
8. А.Оюунчимэг, Тандалт судалгаа, статистикийн албаны статистикч эмч, АУ-ны магистр, ахлах зэргийн эмч
9. Г.Гантуяа, Тандалт судалгаа, статистикийн албаны статистикч эмч

Захирлын 2026 оны сарын өдрийн
тоот тушаалын хавсралт



**“ХҮҮХЭД БОЛОН НЯРАЙ ЯАГААД ЭНДЭВ, ТАВ ХҮРТЛЭХ НАСНЫ
ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭ 2024-2025 “ сэдэвт судалгааны
удирдамж**

Үндэслэл

Хүүхэд, нярайн эндэгдлийн үзүүлэлт нь улс орны нийгмийн хөгжлийн үзүүлэлт болохын зэрэгцээ нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын тодорхой үзүүлэлт болдог.

Дэлхий нийтийн “Тогтвортой хөгжлийн зорилго”-ын 3 дахь зорилтын (3.2) -ын хүрээнд сэргийлэх боломжтой нялхсын ба 1-ээс 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг тэглэх зорилт тавьсан байна.

Монгол Улсад 2014 онд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) 18.5 байсан бол 2023 онд 14.9 болж буурсан хэдий ч хүүхдийн эндэгдэл тууштай буурахгүй, ялангуяа, хот, хөдөө, бүс нутагт ялгавартай байна. Тодруулбал, 2023 онд Улаанбаатар хотод тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 15.7 промил, нярайн эндэгдлийн түвшин 8.5 байгаа нь улс, аймгийн дунджаас өндөр байна.

Монгол Улсад 2023 онд тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 41.7% перинатал (нярай үед) үед үүссэн эмгэг, 15.6% амьсгалын тогтолцооны өвчин, 15.1% төрөлхийн хөгжлийн гажиг, 12.9%-ийг осол гэмтэл эзэлж байна.

Улсын хэмжээний тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 50 гаруй хувийг нярайн эндэгдэл эзэлдэг ба 2023 онд 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн 51.6%-ийг нярайн эндэгдэл эзэлж байна.

Монгол Улсад 2014 онд нярайн эндэгдлийн түвшин (1000 амьд төрөлтөд) 10.0, нярайн эрт үеийн эндэгдлийн түвшин 8.1, хожуу үеийн эндэгдлийн түвшин 1.9 байсан бол 2023 онд нярайн эндэгдлийн түвшин 7.7 промил, нярайн эрт үеийн эндэгдлийн түвшин 5.1 промил болж буурсан хэдий ч нярайн эрт үеийн эндэгдлийн бууралтын хурд удаашралтай, хожуу үеийн эндэгдлийн түвшин 2.6 промил болж өссөн нь анхаарал татаж байна.

Хүүхдийн эндэгдэлд нөлөөлөх хүчин зүйлүүд, эрсдэл, эхийн жирэмсэн үеийн хяналт эрүүл мэндийн байдал, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хожимдол, нийгэм эдийн засгийн хүчин зүйл зэрэг асуудлыг судлан үзэж шалтгааныг тодорхойлсноор хүүхдийн эрүүл мэндийн байдлыг сайжруулах, эндэгдлийг бууруулахад чиглэсэн арга зам интервенцүүдийг боловсруулан хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.

Зорилго

2024-2025 онд Эрт болон хожуу нярай, нялхас, нэгээс тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлүүдийг судлан зөвлөмж боловсруулан, МУ-ын хүүхэд, нярайн эмчийн анхдугаар зөвлөлдөөн зохион байгуулах мөн хүүхэд яагаад эндэв, нярай яагаад эндэв ном хэвлүүлэн гаргах

Зорилт

1. Эрт болон хожуу нярай, нялхас, нэгээс тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан, бүтэц, эрсдэлт хүчин зүйлсийг тодорхойлох
2. Хүүхэд, нярайн сэргийлж болох эндэгдлийн эмнэлгийн тусламж үйлчилгээтэй холбоотой тохиолдлын шалтгааныг тодорхойлох
3. Эрт болон хожуу нярай, нялхас, нэгээс тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулах зөвлөмж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлийг тодорхойлох.

БАТЛАВ. ЭХЭМҮТ-ИЙН ЗАХИРАЛ



Ж.ОТГОНБААТАР

ЭХ ХҮҮХДИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

2024-2025 ОНЫ ЭРТ БОЛОН ХОЖУУ НЯРАЙ, НЯЛХАС НЭГЭЭС ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙН ШАЛТГААНД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ АЖЛЫН ТӨСӨВ

2026 оны 01 дүгээр сарын 23

Улаанбаатар хот

№	Хийгдэх ажил	Төсвийн задаргаа	Төсөв
Судалгааны бэлтгэл ажил			
1	Судалгааны материал орон нутгаас ирүүлэх, буцаах шуудангийн зардал	1791 өвчний түүх*2000 төг*2 удаа	7,164,000.0
	Дэд дүн		7,164,000.0
Дүн шинжилгээ хийх ажлын хэсгийн сургалтын зардал			
2	Өдрийн хоол	60 хүн*1 өдөр-Хоол*25,000 төг/хүн	1,500,000.0
3	Цайны завсарлага	60 хүн*1 өдөр*2удаа*15,000 төг/хүн	1,800,000.0
4	Бичиг хэрэг (дэвтэр, үзэг, хавтас, маркер г.м)	60 хүн*12,000 төг/хүн	720,000.0
	Дэд дүн		4,020,000.0
Анхан шатны бичиг баримтыг уншиж дүгнэлт хийх			
5	Өвчний түүх, түүнтэй адилтгах бүх материалыг уншиж, уншсан материалд дүгнэлт хийх.	2987 өвчний түүх*10,000 төг	29,870,000.0
	Дэд дүн		29,870,000.0
Мэдээлэл боловсруулах			
6	Кодолж, цэвэрлэх, мэдээлэл оруулах, боловсруулах	10 өдөр	6,000,000.0
	Дэд дүн		6,000,000.0
Тайлан бичих, орчуулах			
7	Тайлан бичих	250 нүүр*20,000 төг	5,000,000.0
8	Монгол тайлан хянах	250 нүүр*25,000 төг	6,250,000.0
9	Монголоос англи хэл рүү орчуулах	150 нүүр*30,000 төг	4,500,000.0
10	Орчуулгыг хянах	150 нүүр*35,000 төг	5,250,000.0
	Дэд дүн		21,000,000.0
Бусад зардал			
11	Принтерийн хор	6 ширхэг*60,000 төг	360,000.0
12	Бичгийн цаас	40 боодол*18,500 төг	740,000.0
	Дэд дүн		1,100,000.0
13	Тайланг хэвлэх	100 хувь*60,000 төг	6,000,000.0
14	Хүүхэд яагаад эндэв ном	1000 ширхэг*40000	40,000,000.0

15	Нярай яагаад эндэв ном	1000 ширхэг*40000 төг	40,000,000.0
16	Монгол улсын хүүхэд, нярайн эмч нарын анхдугаар чуулга уулзалт	700 эмч оролцох чуулга уулзалтын зардал: сургалтын зардал, өдрийн хоол, кофе, цай /Гадуур хийх /	91,000,000.0
		Заалны түрээс	5,000,000.0
	Нийт дүн		253,154,000.0

Үйл ажиллагааны чиглэл

- Судалгааны аргачлал, асуумжийг эцэслэн боловсруулах
- Аргачлалын дагуу судалгааг хугацаанд нь чанартай гүйцэтгэх
- Хүүхдийн эндэгдлийн бүртгэл мэдээлэлд дүн шинжилгээ хийж, мэдээлэл цуглуулах
- Тайлан боловсруулах
- Удирдлагын зөвлөл, Эрдмийн зөвлөлд оруулж хэлэлцүүлэх
- МУ-ын Хүүхэд, нярайн эмч нарын анхдугаар чуулга уулзалт зохион байгуулах

Хүрэх үр дүн

1. Эрт болон хожуу нярай, нялхас, нэгээс тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаанд дүн шинжилгээ хийж, авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох
2. Эрт болон хожуу нярай, нялхас, нэгээс тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулахад чиглэсэн эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтнуудад зориулсан зөвлөмж боловсруулах
3. Эрт болон хожуу нярай, нялхас, нэгээс тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг бууруулахад чиглэсэн иргэдэд зориулсан зөвлөмж боловсруулах
4. МУ-ын хүүхэд, нярайн эмчийн анхдугаар чуулга уулзалтыг зохион байгуулах
5. “Хүүхэд яагаад эндэв?”, “Нярай яагаад эндэв?” тус тус 2 ном хэвлүүлэн гаргах.

Хариуцах байгууллага: Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв

Хамтран ажиллах байгууллага: Эрүүл мэндийн яам

Хугацаа: 2026 оны 03 - 08 дугаар саруудад

Нийт төсөв: **253,154,000 төгрөг**